

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ**

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
1.1	Эцэг/эхийн нэр: Равсал Нэр: Ринчинбазар
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. Монгол Улсын иргэн
1.4	Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; Эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэгтэй -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; Улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаанд оролцдоггүй -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; Өр төлбөр байхгүй -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; Сөргөөр нөлөөлөх зүйл үгүй -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ. <ul style="list-style-type: none">албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно); Дарга, СЗХ-ны Хяналтын зөвлөл 2013 оноос Гэрээт профессор, МУИС, 2019 оноос УИХ-ын даргын орон тооны бус зөвлөх, 2013-2016 Тэргүүн дэд захирал, МУИС, 2009-2013 Захирал, МУИС-ийн Математик, компьютерийн сургууль, 200,-2009 Эрхлэгч, МУИС-ийн Хэрэглээний математикийн тэнхим, 2003-2008

	<p>Захирал, ШУА-ийн Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2000-2003 Дэд дарга, ЗГХЭГ, 1997-2000 Дарга, ЗГХЭГ-ын ТЗУГ, 1996-1997 Багш, дэд профессор, МУИС, 1982-1996</p> <ul style="list-style-type: none"> • эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.
<p>1.5</p>	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <p>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</p> <ol style="list-style-type: none"> 1. Монголын эдийн засгийн бүтцийг сайжруулах, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудал 2. Эрүүл мэндийн санхүүжилтийн аргачлалыг боловсруулах нь 3. Төв, орон нутгийн төсвийн харилцааны нийтлэг асуудлууд, олон улсын жишиг 4. Төв, орон нутгийн төсвийн харилцааны шинэчлэлийн асуудлууд 5. Төв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн үр нөлөөг үнэлэх, шилжүүлэг хийх аргачлыг боловсронгуй болгох загвар 6. Татварыг шинэтгэх нь 7. Бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагааны имитац загвар 8. Макро эдийн засгийн бодлогын зарим асуудал 9. Хатуу бодлого зөөлрөх үү? 10. Төсвөө шинэтгэх үү, эдийн засгаа аврах уу, эсвэл аль алийг нь үү? 11. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн шилжилт <p>-үйл ажиллагааны гол агуулга;</p> <ol style="list-style-type: none"> 1. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны захиалгаар бичсэн тайлан, 2013 2. Шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан, 2018 3. “Орон нутаг, бүс нутгийн удирдлага” номонд хэвлэгдсэн лекц, 2018 4. Засаглал хоорондын төсвийн харилцааны талаарх дэлхийн улс орнуудын жишиг хандлага, Монгол Улс дахь засаглал хоорондын харилцаа, төсвийн хуваарилалт 5. Математик загвар, түүний интерактив горимд ажилладаг программ хангамжийг сургалт, судалгаа, практик үйл ажиллагаанд ашиглаж байсан. 6. Татварын шинэчлэлийн асуудлыг хөндөж, “Өдрийн сонин”-ны 2005.10.21-ны дугаарт хэвлүүлсэн өгүүлэл 7. Энэхүү загвар нь бүсийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн стратегийн хувилбаруудад макро эдийн засгийн үнэлгээ хийх; Эдийн засгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд төсөв, татварын бодлогын арга хэмжээний ач холбогдол, дэс дарааллыг тогтоох; Бүс нутагт санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах, дахин хуваарилах механизмуудыг жиших, үнэлэх боломж олгоно.

	<p>8. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүлийн 2006 оны №1-д хэвлэгдсэн өгүүлэл</p> <p>9. “Өдрийн сонин” 2008.10.28-ны дугаарт хэвлэгдсэн өгүүлэл</p> <p>10. “Өдрийн сонин” 2009.03.28-ны дугаарт хэвлэгдсэн өгүүлэл</p> <p>11. Шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан, 2002</p> <p>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Өмнө дурдсан судалгааны болон аргачлал, арга зүйн ач холбогдолтой бүтээлүүд нь тухайн үедээ бодлого, төлөвлөлт, практик үйл ажиллагаанд ашиглаж даж байсан.</p>
<p>1.6</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.</p> <p>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ.</p> <p>Монголын актуарчдын нийгэмлэг, УЗ-ийн гишүүн, 2011 оноос</p> <p>Эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга, 2011-2014</p> <p>Эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, 2008-2018</p> <p>ШУА-ийн Бага чуулганы гишүүн, 1997-2005</p> <p>Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, 1996-2000</p>
<p>1.7</p>	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>Бүтээлийн товч жагсаалтыг хавсаргав.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 2. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, 2020 3. Монгол Улс дахь даатгалын салбарын эрх зүйн орчин, өнөөгийн байдал, цаашдын хандлага, харьцуулсан судалгаа, 2019 <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>Бүтээлийн жагсаалтад байгаа болно.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн хөгжлийн асуудлаар сүүлийн жилүүдэд телевиз, студи, мэдээллийн сайтад ярилцлага өгсөн.</p>

	Тухайлбал, Үндэсний олон нийтийн телевизийн “Алсын хараа - 2050” нэвтрүүлэг, 2022.10.24. гэх мэт.
1.8	Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.
1.9	Сахилгын шийтгэлийн талаар Сахилгын шийтгэл авч байгаагүй.

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

	Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.
2.1	<p>Аливаа улс орны хувьд төр, засгийн газраас явуулж буй төсвийн бодлогын үр өгөөж, үр нөлөө нь эдийн засаг, нийгмийн амьдралд гарч буй өөрчлөлтөд тусгалаа олж байдаг. Улс орны эдийн засгийн макро болон микро түвшинд төрийн зохицуулалтын хүрээнд тодорхой зорилт хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл бол төрийн удирдлагын зүгээс санаачлан хэрэгжүүлж буй төсвийн бодлого, тухайлбал, татвар болон төсвийн зарлага санхүүжилт, улсын хөрөнгө оруулалтын арга хэмжээ байдаг билээ. Татварын нэр төрөл, хувь хэмжээг засаглал хооронд хэрхэн хуваарилахаас хэрэглээ хуримтлалын чиг хандлага, эдийн засгийн хөгжлийн төлөв байдал ихээхэн хамаарна.</p> <p>Төрийн санхүүгийн бодлогын эцсийн үр дүнг илэрхийлэгч төсвийн нийт тэнцэл, урсгал тэнцэл нь мөнгө зээлийн бодлого, гадаад төлбөрийн тэнцэл, үнэ инфляци зэрэг үзүүлэлтүүдтэй нягт уялдан макро эдийн засгийг тогтворжуулах, тэнцвэрийг хангах нэг гол хүчин зүйл, үзүүлэлт болдог.</p> <p>Эдийн засгийн хөгжлийн сонгодог онолын үүднээс авч үзвэл дараах хоёр шаардлагыг хангасан Засгийн газрын төсөв нь улс орны эдийн засгийн хөгжлийн хурдцад эерэг нөлөө үзүүлдэг байна. Энэ нь:</p> <p>Нэгд, эдийн засаг дахь Засгийн газрын оролцоо аль болох бага байх ёстой, Хоёрт, татварын дарамт аль болох бага байх ёстой гэсэн шаардлага юм.</p> <p>Ардчилсан тогтолцоотой улс орнууд холбооны улсын зохион байгуулалттай байна уу, эсвэл унитар улс байна уу гэдгээс үл хамааран төрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах, улс төрчдөөс сонгогчдын өмнө хүлээх хариуцлага, тэдэнд тайлагнах шаардлагыг илүүтэй хангах, түүнчлэн иргэдэд үзүүлж буй төрийн бүхий л үйлчилгээг тоо, чанарын хувьд эцсийн хэрэглэгчдийн шаардлагын түвшинд хүргэх, үр ашгийг дээшлүүлж, хөрөнгийн чадавхыг сайжруулах зэрэг олон хүчин зүйлээс хамаарч орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах нийтлэг чиг хандлагыг баримталж байна. Гэхдээ энэхүү үйл явц нь хуваарилалтын адил тэгш зарчим, макро эдийн засгийн менежмент, нэн ялангуяа төсвийн удирдлагын хувьд тодорхой сөрөг үзэгдлийг дагуулсаар байдаг. Төсвийн харилцаа нь юуны өмнө зарлага санхүүжилтийн хуваарилалтын асуудлыг хөнддөг бөгөөд үүнийг шийдвэрлэсэн нөхцөлд түүнийг ямар эх үүсвэрээр хангах тухай асуудал гарч ирдэг.</p>

Засгийн газар ба орон нутаг хоорондын зарлага санхүүжилтийн хуваарилалтыг хийхэд ямар орлогыг орон нутгийн мэдэлд өгөх, орон нутгийн төсвийг төв Засгийн газрын төсвөөс бүрэн хараат байлгах уу, эсвэл хагас хараат байлгах уу, эсвэл огт хамааралгүй байлгах уу гэсэн нарийн түвэгтэй асуудлууд тулгардаг бөгөөд энэ нь нэг талаар эдийн засгийн онолын түвшинд тун бага судлагдсан, нөгөө талаар хэдийгээр зарим судалгаа байдаг авч тэр нь үзэл бодлын зөрүү, эерэг сөрөг талын аль нь давуутай болохын хувьд эцэслэн тогтсон ямар нэгэн хувилбар байхгүй байна.

Бидний зүгээс судалж, ойлгосноор улс орнууд хөгжлийн түвшин, улс төрийн тогтолцооны хэлбэр, туулж ирсэн хөгжлийн замнал, баримталж ирсэн болон баримталж буй хөгжлийн бодлогоос хамаарч төсвийн нэгдсэн бодлого, төв, орон нутгийн хоорондын хөрөнгийн шилжүүлэг, хуваарилалтыг хэд хэдэн төрөл хэлбэрээр, өөрийн онцлогтоо тохируулан хэрэглэж байна. Үүнд:

- Тухайн улс засаглалын ямар тогтолцоогоор хөгжиж ирсэн, одоо ямар тогтолцоотой улс болох,
- Хөгжлийн түвшнээр олон улсын түвшинд ямар ангилалд багтаж байгаа болох,
- Зах зээлийн эдийн засагтай юу, эсвэл төвлөрсөн тогтолцоотой улс уу,
- Газар нутгийн хэмжээ ба суурьшил, нягтаршлын байдал, (багахан газар нутагтай хот улс уу, эсвэл томоохон газар нутагтай улс уу)
- Хүн амын нягтаршил, суурьшил нь их үү, бага уу гэх мэт олон нөхцөлөөс хамаардаг байна.

Миний бие судлаачийн хувиар Монгол Улсад засаглал хоорондын төсвийн хуваарилалт, харилцааны тогтолцоог боловсронгуй болгох, татварын тогтолцоог шинэтгэх, Монголын нөхцөлд ашиглах салбар хоорондын балансын динамик загвар боловсруулах, орон нутгийн удирдлагын тогтолцоо ба эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгох, төсөв хоорондын шилжүүлгийн үр нөлөөг үнэлэх загвар боловсруулах чиглэлээр хийж, гүйцэтгэсэн ажлууд холбогдох хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн чиг үүрэг, тухайлбал, төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах болон төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулахад зохих хувь нэмэр оруулж болох талтай гэж үзэж байна.

Дашрамд хэлэхэд, сүүлийн үед энэ чиглэлээр дорвитой зүйл хийгээгүй болохоо учирлая.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Равсал

Өөрийн нэр: Ринчинбазар

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2023.12.06.

--- оОо ---